



ӨМӨЗО-Ы “ОДОН” ТЕЛЕВИЗ БОЛОН МОНГОЛ УЛСЫН МҮОНТ-ИЙН МЭДЭЭЛЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГЫН СУДАЛГАА

Т.Өнөрсайхан*, Зууна**, Булбарай***, Өрнөл****

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D.)*

***МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн магистрант*

****МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн магистрант*

*****МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн магистрант*

Түлхүүр үгс. телевизийн мэдээ, мэдээллийн хөтөлбөр, мэдээ, сурвалжилга, суваг

Оршил. Телевизийн олон нийтийн дунд үзүүлэх нөлөө болон нэр хүндийг тодорхойлох гол хүчин зүйлүүдийн нэг нь мэдээллийн хөтөлбөр билээ. Технологийн дэвшилтэт шинэ боломжууд гарч ирэх бүрд уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг үгүйсгэх, үр нөлөөг нь хэт багаар үнэлэх зэрэг сөрөг хандлага ажиглагдаж байна. Гэтэл сэтгүүл зүйн бүтээлийн эцсийн хүлээн авагчид, зорилтот бүлэг болох үзэгч, уншигчдын насны онцлог, хүсэл сонирхол, хүлээн авах нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн боломж зэрэг нь харилцан адилгүй байдаг гэдгийг санах хэрэгтэй. Сэтгүүл зүй нь олон нийтийн харилцааг бүрдүүлэгч хүчин зүйлийн нэг болохын хувьд уншигч, үзэгчдийн олон талт байдлыг хангаж, хэвлэл мэдээллийн

хэрэгслүүд ч янз бүрийн хэлбэрээр оршин тогтнож байна. Тэр дундаа телевиз мэдээллийн хөтөлбөрөөрөө дамжуулж нийгмийн харилцааны олон талт урсгалыг бүрдүүлэгч үүргээ биелүүлдэг. Тус судалгааны өгүүллээр өргөн нэвтрүүлгийн телевизүүд болох Өвөр Монголын Өөртөө Засах Орон ӨМӨЗО-ы Монгол “Одон” телевиз болон Монгол улсын Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз МҮОНТ-ийн мэдээллийн хөтөлбөрүүдийг харьцуулан судаллаа.

Үндсэн хэсэг. Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО) нь хэл соёл, угсаатны нийтлэг онцлог, түүнчлэн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хөгжил, зорилго, төрийн бодлогын чиглэл зэргээрээ ялгаатай. Энэхүү судалгааны зорилго нь ӨМӨЗО-ы Монгол “Одон” телевизийн мэдээний хөтөлбөрийг Монгол “Одон” телевиз болон Монгол улсын Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз МҮОНТ-ийн мэдээллийн хөтөлбөр, контент, хөтлөлтийн хэв маяг болон бодлогын нөлөөллийн бодлого, үзэгчийн чиг баримжааны хүрээнд харьцуулан шинжлэхэд оршино. (ӨММХТРГ, 2022)

Өвөр Монголын радио нэвтрүүлгийн ажил 1950 оноос эхэлсэн бөгөөд 1960-аад онд телевизийн үйл ажиллагаа эхлэв. 1976 онд монгол хэлний телевизийн нэвтрүүлгийг албан ёсоор цацаж эхэлсэн нь монгол хэл дээрх дүрс, дууны мэдээллийн тогтолцоо бүрэлдэн тогтоход чухал нөлөө үзүүлсэн үе байлаа. 1980-аад онд монгол хэлний нэвтрүүлэг нэмэлтээр хэсэгчлэн гардаг байдлаасаа салж, бие даасан суваг болон хөгжсөн юм. Улмаар 1997 оны 1-р сарын 1-нд хиймэл дагуулаар дамжин олон нийтэд цацагдах боломж бүрдсэнээр, илүү өргөн хүрээг хамарсан ӨМӨЗО-ы Монгол “Одон” телевиз бүтээн байгуулагдсан байна.

Монгол Улсын үндэсний радио, телевизийн байгууллагын үндэс суурь нь ХХ зуун дунд үеэс тавигдсан бөгөөд телевизийн салбарын эхлэл нь 1967 оны 9-р сарын 27-нд анхны зурагтын эфирээр эхэлсэн юм. Анх бүх нэвтрүүлгүүд шууд байдлаар хийгддэг байсан бол 1971 онд студитэй болж, дүрс бичлэгийн технологи нэвтэрч, баримтат кино, богино хэмжээний кино дүрсийг урьдчилан бэлтгэх боломжтой болжээ. 1991 онд Монголын Үндэсний Телевиз (MNB) нь AsiaSat хиймэл дагуулын системээр дамжуулан нэвтэрсэн нь алслагдсан бүс нутгууд, хилийн доторх болон гадаад дахь монголчуудад хүртэл мэдээлэл хүлээн авах үндэс суурь болсон чухал алхам байв. 2005 онд Монгол Улсын Засгийн Газар “Олон нийтийн радио, телевизийн тухай хууль”-ийг баталснаар, уламжлалт төрийн өмчийн зурагтын системээс “олон нийтийн үйлчилгээ үзүүлэгч” (public service broadcaster) байгууллага болон өөрчлөгдөж, хууль эрх зүйн хүрээнд бий даасан боломж бий болсон. Энэ нь мэдээллийн хараат бус байдал, олон нийтэд тэгш үйлчилгээ үзүүлэх зарчмын хувьд том дэвшил байв.

Монголын Үндэсний Телевиз нь 2006 оны 1 сарын 1-ээс эхлэн шинэ бүтцээр солигдож, радио, телевиз, мэдээ агентлаг нэгдэн олон нийтийн радио телевизийн байгууллага болов. 2000-2010 оны үеийг дамнасан хөгжлийн явцад олон төрлийн мэдээ, нэвтрүүлгийн сувгийг нээсэн. Жишээ нь, Монголын Үндэсний Телевиз -2 суваг нь үндэстний цөөнхөд чиглэсэн мэдээ, нэвтрүүлгийг боловсрол, соёл, мэдээллийн хөтөлбөрүүдийг Казах, Буриад, Тува зэрэг хэлээр дамжуулдаг байв.

Энэхүү судалгаанд 2025 оны 9-11 сарын хоорондох хэсэгчилсэн мэдээллийг судалгааны объект болгон сонгон авсан бөгөөд энэ нь сүүлийн үеийн Өвөр Монголын монгол хэлний суваг болон Монгол Улсын мэдээний нэвтрүүлгийн агуулга, зохион байгуулалт болон үзэгчдийн хариу үйлдлийн онцлогийг тусгасан болно. Тодорхой хугацааг хязгаарлан сонгосон нь судалгаанд мэдээллийн шинэчлэгдсэн байдал хадгалагдаж, нэвтрүүлгийн тодорхой тохиолдлуудыг гүнзгий судлах боломжтой болохын зэрэгцээ монгол хэлний мэдээллийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагын талаар бодитой дүгнэлт хийх боломжийг олгоно.

ӨМӨЗО-ы Монгол “Одон” телевизийн мэдээний агуулгыг улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, технологи гэсэн таван ангилалд ерөнхий байдлаар хуваан авч үзэв. Үүнээс аялал жуулчлал, спортын тэмцээн зэрэг соёл, аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой мэдээний сэдвийг соёлын төрөлд, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл зэрэг хөдөө аж ахуйн мэдээллийг эдийн засгийн төрөлд тус тус багтаасан болно. ӨМӨЗО-ы Монгол “Одон” телевизийн нэвтрүүлгийн үргэлжлэх хугацаа ойролцоогоор 20 минут байна. Өдөрт дунджаар долоон төрлийн сэдвээр гарсан мэдээ, мэдээллийг дээжлэн шинжилсэн судалгааны үр дүнд мэдээний гол агуулга нь улс төр, эдийн засаг болон соёлын гэсэн гурван төрөлд төвлөрч байгааг харуулж байна. ӨМӨЗО-ы Монгол “Одон” телевизийн мэдээний улсын болон мужийн түвшний хэвлэлийн тогтолцоонд харьяалагддаг тул мэдээний агуулга нь зайлшгүй төр засгийн бодлогын чиг шугамд нийцдэг байх онцлогтой. Иймээс улс төрийн төрөлд хамаарах мэдээний эзлэх хувь харьцангуй өндөр бөгөөд голчлон улсын бодлого, намын чуулган, өөртөө засах орны томоохон хурлын мэдээлэл, удирдлагын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг хамардаг. Эдийн засгийн мэдээнүүд нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, үйлдвэрлэлийн шинэчлэлтэй уялдан эрчим хүчний төсөл, томоохон салбарын хөгжлийн бодлого, хөдөө аж ахуй, худалдаа арилжааны чиглэлийн мэдээллээр давамгайлдаг. Харин соёлын төрөлд аялал жуулчлал, спортын арга хэмжээ, үндэсний уламжлалт соёлын үйл ажиллагаа голлох байр суурь эзэлж, бүс нутгийн соёлын онцлог, аялал жуулчлалын хөгжлийн төлөвийг харуулдаг. Анхаарал татах нэг зүйл нь тус сувгийн чиг үүрэг нь өөртөө засах орны дотоод мэдээллийг хүргэхэд чиглэдэг тул олон улсын мэдээний эзлэх хувь маш бага, зарим хугацаанд

бараг гардаггүй байна. Ерөнхийд нь дүгнэвэл, ӨМӨЗО-ы Монгол “Одон” телевизийн мэдээний бүтэц нь өөртөө засах орны улс төрийн чиг бодлого, эдийн засгийн хөгжил болон нийгэм соёлын амьдралд төвлөрснөөр бүс нутгийн хэвлэл мэдээллийн онцлог болон түүний суртал нэвтрүүлгийн үүргийг тодорхой харуулж байна.

Монголын үндэсний олон нийтийн телевиз (МҮОНТ)-ийн мэдээний агуулгад хийсэн түүвэр судалгаа, статистик шинжилгээний үр дүнгээс үзэхэд тус нэвтрүүлэг нь өдөр бүр дунджаар 8-12 сэдвийн мэдээ хүргэдэг байна. Түүвэрлэсэн мэдээнүүдийн бүтэц, агуулгаас харахад мэдээллийн ихэнх хэсэг нь технологи болон олон улсын ангилалд төвлөрч байна. Технологийн төрлийн мэдээ нь ихэвчлэн шинжлэх ухааны хурал, судалгааны ажлын үр дүнгийн танилцуулга, инженерийн бүтээн байгуулалт, цаг уур ба байгаль орчны хяналт шинжилгээ зэрэгтэй холбоотой мэдээллээс бүрдэх бөгөөд энэ нь Монгол Улс сүүлийн жилүүдэд шинжлэх ухаан, инновац, технологийн хөгжилд өндөр ач холбогдол өгч буйг харуулж байна. Харин олон улсын мэдээлэл нь дипломат харилцаа, бүс нутгийн болон олон талт хамтын ажиллагаа, олон улсын форум, Монгол Улсын хөрш орнууд болон өргөн хүрээний бүс нутгуудтай хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны тухай мэдээнүүдийг хамардаг. Улсын хэмжээнд мэдээ, мэдээлэл түгээдэг байгууллага учраас МҮОНТ-ийн мэдээллийн агуулга нь сэдэв сонголт болон бүтэц зохион байгуулалтын хувьд төрийн бодлогын чиг баримжаа, хэвлэл мэдээллийн үндэсний үүрэг тодорхой тусгалаар илэрдэг. Технологийн мэдээний дийлэнх хувь нь инновацад суурилсан хөгжил, шинжлэх ухаан технологийн тогтолцоог бэхжүүлэх төрийн бодлоготой уялдаж байгаа бөгөөд олон улсын мэдээний өргөн цар хүрээтэй байдал нь Монгол Улсын гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон нээлттэй бодлогын идэвхтэй байр суурийг харуулж байна. Мөн бүсийн хэвлэл мэдээлэлтэй харьцуулахад МҮОНТ нь улсын хэмжээний бодлогын мэдээ, олон улсын хамтын ажиллагааны үйл явц, улсын томоохон арга хэмжээ зэргийг түлхүү тусгадаг тул мэдээллийн шуурхай байдал, эрх мэдэл, бодлогын шинж чанар илүү тод харагддаг.

Ерөнхийд нь авч үзвэл, Монголын үндэсний олон нийтийн телевиз (МҮОНТ)-ийн мэдээний бүтэц нь нэг талаас улсын стратегийн зорилт болох технологи, инновацын чиглэлийг онцлон харуулдаг бол нөгөө талаас олон улсын мэдээллийн өргөн хүрээг хадгалсан хэвээр байгаа нь мэдээний бүтэц, ангиллын гол онцлогийг бүрдүүлж байна. МҮОНТ нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд улс төрөөс хараат бус, олон нийтийн эрх ашгийг дээдэлсэн бүтэцтэй. Хөтөлбөрүүд нь үнэн бодит мэдээлэл түгээх, иргэдийг мэдээд хэрэгтэй шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 1. ӨМӨЗО-ы Монгол Одон телевизийн 2025 оны мэдээний эзлэх хувь

Он, сар, өдөр	Улс төрийн мэдээ	Эдийн засгийн мэдээ	Боловсролын мэдээ	Соёлын мэдээ	Технологи
9 сарын 19	14%	29%	0%	43%	14%
10 сарын 11	57%	29%	0%	0%	14%
11 сарын 10	17%	50%	0%	33%	0%

Хүснэгт 2. Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз (МҮОНТ)-ийн 2025 оны мэдээний эзлэх хувь

Он, сар, өдөр	Олон улсын мэдээ	Эдийн засгийн мэдээ	Боловсролын мэдээ	Соёлын мэдээ	Технологи
9 сарын 10	25%	11%	20%	25%	18%
10 сарын 29	37%	12.5%	25%	25%	10%
11 сарын 7	17%	8%	17%	25%	33%

Судалгааны үр дүн. Дээрх хүснэгтийн бүтэц нь улс төр, нийгэм, эдийн засгийн бодит үйл явдлыг илүү өргөн хүрээнд тусгадаг. Тухайлбал, тус байгууллага улс төр, нийгмийн асуудал, олон улсын харилцаа, соёл урлаг, спорт, болон хөдөө аж ахуй, байгаль орчин зэрэг өргөн хүрээний ангиллыг ашигладаг. Энэ нь олон нийтийн мэдээллийн байгууллагын үндсэн үүрэг болох “үндэсний нийтлэг мэдээллийн хэрэгцээг хангах” чиглэлийн илрэл юм (Жаргалсайхан, 2018). Харин ӨМӨЗО-ы одон телевизийн агуулга

нь илүү төвлөрөгдсөн бүтэцтэй. Сэдвийн гол чиглэл нь төрийн бодлого, намын хурал, бүс нутгийн хөгжил, бүтээн байгуулалт, үндэсний соёлын өв болон нийгмийн тогтвортой байдлыг дэмжсэн контентод төвлөрдөг. Энэ нь БНХАУ-ын төрийн хэвлэл мэдээллийн системийн онцлог болох “зохион байгуулалттай, бодлогын чиглэлтэй контент”-ын давтагдсан шинжтэй.

Контентын баримтат шинж чанар, суртал ухуулгын өнгө аяс. МҮОНТ-ийн контент нь тоо баримт дээр тулгуурласан, асуудлыг олон талаас нь авч үзэх хандлагатай байдаг. Мэдээнд эх сурвалжийн олон талт байр суурийг тусгах, асуудлын шалтгаан үр дагаврыг тайлбарлах хандлага ажиглагдана. Энэ нь сүүлийн жилүүдэд олон нийтийн телевизийн редакцын бие даасан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хийгдсэн шинэчлэлийн үр дүнтэй холбоотой байдаг (Batjargal, 2020). Харин ӨМӨЗО-ы одон телевизийн контентын өнгө аяс нь эерэг, уриалан дэмжсэн байдал давамгайлдаг. Мэдээний урсгалд бүс нутгийн хөгжил, амжилт, төрийн бодлогыг хэрэгжүүлсэн үр дүнг харуулах нь түлхүү. Ийм хэв маяг нь Хятадын хэвлэл мэдээллийн тогтолцоонд түгээмэл хэрэглэгддэг “positive reporting” стратегитай уялддаг.

Үзэгчдэд хүртээмжтэй байдал. МҮОНТ нь үндэсний олон нийтийн мэдээллийн хэрэгсэл тул нийт үзэгчдэд зориулан тогтвортой хэд хэдэн контент түгээдэг. Харин ӨМӨЗО-ы одон телевиз нь БНХАУ-ын үндэсний цөөнхийн хэл соёлын бодлогын хүрээнд ажилладаг тул монгол хэлтэй иргэдэд чиглэсэн контент түгээх зорилготой бөгөөд бодлогоор зохицуулагдсан мэдээлэл давамгайлдаг.

Хэл найруулга ба хөтлөлтийн хэв шинж. Хэлний хэрэглээнд МҮОНТ-ийн мэдээний найруулга нь орчин цагийн хэв маягтай, стандарт монгол хэлний дагуу боловсруулдаг. Харин ӨМӨЗО-ы одон телевиз нь монгол, хятад хос хэлээр мэдээлэл түгээдэг бөгөөд монгол хэлний хувьд ӨМӨЗО-ы баримжаа аялгууны онцлог илүүтэй ажиглагддаг.

Хөтлөгчийн хэв маяг. МҮОНТ-ийн хөтлөлт илүү чөлөөтэй, харьцангуй орчин үеийн илэрхийлэлтэй байхад ӨМӨЗО-ы одон телевизийн хөтлөгчид илүү албан ёсны, тогтсон хэв маягтай, улс төрийн мэдээлэл дамжуулах хэм хэмжээг баримталдаг.

Найруулгын бүтэц. МҮОНТ: Асуудал, шалтгаан, үр дагаврыг тодорхой тайлбарласан, эх сурвалцын олон талт байр суурийг тусгасан найруулгатай. ӨМӨЗО-ы одон телевиз: Товч, шууд, бодлогын тайлбар давамгайлсан, албан ёсны бүтэцтэй.

Техник, технологийн ашиглалт. МҮОНТ нь сүүлийн жилүүдэд өндөр чанартай HD нэвтрүүлэг, автоматжуулсан систем, студийн шинэчлэл хийж, олон улсын стандартай дүйцэхүйц түвшинд хүрсэн. Харин ӨМӨЗО-ы одон телевиз нь Хятадын төв телевизийн сүлжээний нэг хэсэг тул олон камерын

өндөр нарийвчлалын систем, бүрэн тоноглогдсон студи ашигладаг.

Үзэгчдийн хамрах хүрээ ба нөлөөлөл. МҮОНТ нь улс орон даяар хамгийн өргөн хүрээтэй телевизийн сүлжээ бөгөөд мэдээллийн гол эх сурвалж хэвээр байна. Үзэгчдийн шийдвэр гаргалтад бодит мэдээллээр дэмжлэг үзүүлдэг. ӨМӨЗО нь одон телевиз нь ӨМӨЗО-ы монгол хэлтэй үзэгчдэд чиглэсэн мэдээллийн гол эх сурвалж боловч контент нь төрийн бодлогын нөлөөлөлтэй. Үзэл санааны нэгдмэл байдлыг бий болгох чиглэл давамгайлдаг.

Дүгнэлт. МҮОНТ-ийн мэдээний хөтөлбөр нь Монгол Улсын медиа орчны чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд олон талаас нь судлахад тодорхой давуу болон сул талууд ажиглагддаг. Давуу тал нь өргөн хүрээний мэдээлэл хүргэх чадвар (улс даяарх болон олон улсын мэдээ), албан ёсны эх сурвалжийг ашиглах, мэргэжлийн түвшний хөтөлбөрийн бэлтгэл, нийгмийн гол ач холбогдол бүхий сэдвийг хөнддөг олон нийтийн үйлчилгээ зэрэг орно. Харин сул тал нь төрийн өмчит байдал, төвлөрсөн хандлага, олон талын дуу хоолойг бүрэн тусгаж чадахгүй байх зэрэг магадлалтай. Үзэгчид олон төрлийн эх сурвалжид тулгуурлан мэдээллийг харьцуулж, шүүмжлэлтэй хандах нь чухал бөгөөд мэдээллийн олон талт байдал, төвийг сахисан байдал нь ардчилсан нийгмийн хөгжлийн үндсэн нөхцөл болдог. Энэхүү харьцуулсан судалгаанаас харахад Өвөр Монголын Өөртөө Засах Орон ӨМӨЗО-ы Монгол “Одон” телевиз болон Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз МҮОНТ-ийн мэдээний хөтөлбөрүүд нь хэл, соёлын нийтлэг уламжлалтай боловч улс төрийн бодлого, эрх зүйн орчин, зорилго, контентын шинж чанараар эрс ялгаатай байна. МҮОНТ илүү ардчилсан, олон талт, иргэдэд чиглэсэн мэдээллийн системтэй бол, ӨМӨЗО-ы одон телевиз нь төрийн тодорхой бодлогыг хэрэгжүүлэх чиглэл давамгайлсан, эерэг өнгө аястай контент голлон түгээдэг нь ажиглагдлаа. Иймээс хоёр сувгийн мэдээний хөтөлбөр нь үзэгчдэд үзүүлэх нөлөө, мэдээллийн төрөлжсөн байдал, сонголтын боломжийн хувьд ялгаатай байх нь тодорхой байна.

Эшлэл

Өвөр Монголын Мэдээ, Хэвлэл, Телевиз, Радио газар, 2022. *Media нэгдсэн хөгжлийн үед Өвөр Монголын радио, телевизийн хөгжлийн тайлан*. Хөх хот. х.45–47.

J.Batjargal, B.Tsend-Ayush, 2020. Media Transformation in Mongolia. *Journal of Asian Communication*.30(4), 415–432.

Жаргалсайхан Д, 2018. *Монголын хэвлэл мэдээллийн хөгжил ба олон нийтийн телевизийн үүрэг*. УБ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

Mongolian National Broadcaster. 2025. UNESCO ICHCAP Digital Archive.

Zhao, Y. 2008. *Political Economy, Power, and Conflict*. Rowman & Littlefield. China

Lee, C. 2010. *Chinese Media, Global Contexts*. Routledge. China

https://www.jamco.or.jp/en/symposium/24/4/?utm_source

<https://m.tvyan.com/tv/neimeng-mengyu/>

Summary

The Mongolian National Broadcaster (MNB) plays a central role in Mongolia's media, offering nationwide and international news with professional production and public-interest content. Its strengths include wide coverage and official sources, while weaknesses involve state ownership and limited dissenting perspectives. In contrast, NMTV emphasizes state policy implementation and presents predominantly positive content. Although both share linguistic and cultural traditions, they differ in political orientation, objectives, and content style, providing audiences with distinct perspectives and varying informational diversity.

Keywords: television news, information program, news, report, channel